



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/120

Арвайхээр сум

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл (Өвөрхангай, Арвайхээр Хархорин, Хужирт сум) ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орон гүйцэтгэгч)

Гишүүд: Э.Тэгшбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын , хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Ц.Оюун (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Г.Гантөмөр (Оновчтой хөгжил ТББ-ын тэргүүн) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичиг: Б.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Ц.Идэрсайхан)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

0224 11 0253